

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХОА-2024/25-19-ШТА-ГА

Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэлгүй, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг төлөвлөснөөр хөрөнгө оруулалтыг зарим ажлууд нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Ховд хот
2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn
Аудитор: Д.Мөнхтулга
Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn
Аудитор: У.Батчимэг
Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn
Аудитор: А.Нарандэлгэр
Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn
Аудитор: М.Энхжаргал
Цахим хаяг: enkhjargalm@audit.gov.mn
Аудитор: Н.Батжаргал
Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Тайланг хянасан:	
Ховд аймаг дахь аудитын газрын тэргүүлэх Х.Болдбаатар	Төрийн дарга, аудитор
Тайланг бэлтгэсэн:	
Аудитын менежер А.Цэцэгсүрэн	
Ахлах аудитор Д.Нарантуул	
Аудитор Д.Мөнхтулга	
Аудитор А.Нарандэлгэр	
Аудитор У.Батчимэг	
Аудитор Н.Батжаргал	
Аудитор М.Энхжаргал	
2024 оны 7 дугаар сарын 05-ны өдөр	
Тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.	
ХАЯГ: Ховд аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар	

АГУУЛГА	
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЖУРАМД ЗААСАН НӨХЦӨЛ, ШАЛГУУРЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, СУМДАД ОЛГОХ ЭХ ҮҮСВЭРИЙГ ДУТУУ ХУВААРИЛЖЭЭ	6
1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг холбогдох хуульд заасны дагуу төлөвлөсөн ч сумдад олгох санхүүжилтийг 2,910.1 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.	6
1.2 Зарим сумууд сангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого чиглэлтэй уялдуулан батлаагүй, хуулийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталснаас төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байна.	8
БҮЛЭГ 2. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД НИЙТ 845 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТЛАГДСАНААС 81.3 ХУВЬ НЬ БҮРЭН, 10.7 ХУВЬ НЬ ДУТУУ ХЭРЭГГИЖ, 8 ХУВЬ НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.	11
2.1 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж төсвийг хэт жижиглэн баталсан, сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүйгээс сая төгрөгөөр үргүй зардал гаргасан байна.	11
2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь зарим нь орон нутгийн хөгжилд үр өгөөжтэй, ард иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлсэн ч төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй байна.	14
2.3 Сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулан хариуцах эзнийг тодорхой болгох, ашиглалтын зардлыг төлөвлөх шаардлагатай байна.	15
БҮЛЭГ 3: ОНХС-ИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭН ГАРГААГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БЭЛТГЭСЭН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ, УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН ОРУУЛААГҮЙ БАЙНА.	16
3.1. ОНХС-ийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас хяналтыг хэрэгжүүлсэн ч илэрсэн алдаа зөрчил бүрэн арилаагүй байна.	16
3.2 Сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг журамд заасны дагуу тайлагнаж хүргүүлээгүй байна.	18
БАЙГУУЛЛАГУУДААС ИРСЭН САНАЛ	222
САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР	Error! Bookmark not defined.2
ДҮГНЭЛТ	21
ЗӨВЛӨМЖ	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УМС	Удирдлага мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХНС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 2	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт	19
Хүснэгт 3	Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
Хүснэгт 4	Тайлан хүргүүлэх хугацаа, мэдээлэл	20

Дүрслэлийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХС-гийн орлогын хуваарилалт	9
Дүрслэл 2	Тогтвортой амьжиргаа төслөөр авсан урамшуулал	9
Дүрслэл 3	ОНХС-ийн урамшуулалд хамрагдалтын байдал (сумдаар)	9
Дүрслэл 4	Санал өгсөн иргэдийн тоо	10
Дүрслэл 5	Иргэдийн мэдээллийн талаарх санал асуулгын дүн	11
Дүрслэл 6	Батлагдсан төсөл арга хэмжээ	12
Дүрслэл 7	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	13
Дүрслэл 8	Худалдан авах ажиллагааны хэлбэр	14
Дүрслэл 9	ТАХ-ны хэрэгжилт	15
Дүрслэл 10	УМС-д оруулсан мэдээлэл	22
Дүрслэл 11	УМС-д оруулсан мэдээлэл	22
Дүрслэл 12	ОНХС-ийн гүйцэтгэл (сая.төгрөг	23

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх Аудитын зорилт Аудитын хамарсан хүрээ Аудитын арга зүй Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт Хүндрэл бэрхшээл	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дүгээр тушаалаар баталсан “Аудитын сэдэв батлах тухай”, А/152 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу аудитыг гүйцэтгэв. Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➢ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; ➢ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; ➢ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх. Аудитад аймаг,сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, багийн Засаг дарга, аймаг, сумын ОНХС-ийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав. Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.
	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: – Төсвийн тухай хууль – Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль – Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; – Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; – Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; – Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; – МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал” – Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” – Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” – Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд; – Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд
	Аймгийн ЗДТГ-аас 661.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээг хууль хяналтын байгууллагад хандан шалгуулж байгаа тул энэ аудитаар авч үзээгүй болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн хөгжлийн сан нь Засгийн газраас орон нутгийг хөгжүүлэх зорилгоор хөдөө орон нутагт тулгамдаж буй асуудлыг орон нутгийн иргэдийн саналд үндэслэн нэн шаардлагатай арга хэмжээг шийдвэрлэх зорилготой.

ОНХС-ийн үйл ажиллагаа иргэдийн оролцоотой төлөвлөлт, төслийн үнэлгээ эрэмбэлэлт, хэрэгжилт болон худалдан авах ажиллагаа, хяналт-шинжилгээ үнэлгээ, хөрөнгийн удирдлага гэсэн үндсэн 5 үе шаттай явагддаг.

Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөгдөж тайлант онд Монгол улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг шинэчлэн баталжээ.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 12,290.4 сая төгрөгөөр баталж, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн төсвийн хуульд нэмэлт өөрчлөлтөөр 19,225.4 сая төгрөг болж 6,965.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан “Удирдлагын мэдээллийн систем”-д оруулахаар заажээ.

БҮЛЭГ 1. САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЖУРАМД ЗААСАН НӨХЦӨЛ, ШАЛГУУРЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, СУМДАД ОЛГОХ ЭХ ҮҮСВЭРИЙГ ДУТУУ ХУВААРИЛЖЭЭ.

1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг холбогдох хуульд заасны дагуу төлөвлөсөн ч улсын төсвөөс олгох санхүүжилтийг дутуу олгожээ.

1.1.1. Аймгийн ИТХ-аас аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу ОНХС-ийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 18,602.5 сая, “Тогтвортой амьжиргаа 3” төслийн урамшууллаас 652.8 сая, өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 3,683.0 сая, малын тоо толгойн албан татварболон бусад орлогоос 1,491.3 сая, хандив 8,143.0 сая нийт 32,572.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр ОНХС-ийн нэгдсэн сангаас 18,398.3 сая, Тогтвортой амьжиргаа төслөөс 652.8 сая төгрөгийг урамшуулалд, дотоод, гадаадын хандив тусламжаар буюу Хөшөөтийн уул уурхайгаас 7,745.3 сая, өмнөх оны үлдэгдэл, бусад орлогоос 260.4 сая, малын тоо толгойн албан татвараас 772.4 сая нийт 27,856.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж 4,716.6 сая төгрөгөөр орлого тасарсан байна.

Энэ нь улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг 204.3 сая, уул уурхайгаас орох орлого 397.7 сая, малын тоо толгойн албан татварын орлого 451.4 сая төгрөгөөр эх үүсвэрийг дутуу бүрдүүлжээ.

Хүснэгт 1.ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
1	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	18,602.6	18,398.3	204.3	98.9
2	"Тогтвортой амьжиргаа 3" төслийн урамшуулал, дэмжлэг	652.8	652.8	0.0	100.0
3	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлийг ИТХ-аас баталсан	3,683.8	73.6	3,610.2	2.0
4	ТТХ-ийн 60.2.4-д "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"	100.0	-	100.0	0.0
5	ТТХ-ийн 60.2.5, ЗГ-ын 2017 оны 230-р тогтоолын 2.2.4, тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг /ТТХ-ийн 59.1.3 хамаарахгүй зөвхөн тухайн орон нутагт/ (Хөшөөтийн уул уурхай)	8,143.0	7,745.3	397.7	95.1
6	Малын тоо толгойн татвар	1,223.8	772.4	451.4	63.1
7	Бусад орлого	166.6	213.6	-47.0	128.2
ДҮН		32,572.6	27,856.0	4,716.6	85.5

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан



1.1.2 Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2-д заасны дагуу ОНХС-ийн орлогын шилжүүлгийг, сумдад 50 хувиас багагүй байхаар тусгаж гүйцэтгэлээр аймагт 45.6 хувь буюу 8,490.9 сая, сумдад 54.3 хувь буюу 10,111.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталжээ.

1.1.3 Аймгийн ИТХ-аас аймгийн ОНХС-д 8,490.9 сая, сумдын ОНХС-д 10,764.5 төгрөг баталсны дагуу батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу олгожээ.

Орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ард иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5¹-т заасны дагуу 2023 онд 6 сумд 652.8 сая төгрөгийн урамшуулал олгохоор батлагдсан нь өмнөх оноос 353.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн 17 сумдаас ОНХС-ийн урамшуулалд Дарви, Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад, Мөнххайрхан, Мөст, Цэцэг сумд хамрагдаагүй байхад зарим сумдууд жил бүр урамшуулал авч байна.

Дүрслэл 3: ОНХС-ийн урамшуулалд хамрагдалтын байдал (сумдаар)



ОНХС-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг “олон нийтийн оролцоо”, “төлөвлөлт”, “ил тод байдал”, “хэрэгжилт”, “хяналт, шинжилгээ-үнэлгээ”, “өмчлөл” гэсэн 6 бүлгийн 34 үзүүлэлтээр дүгнэхэд хэрэгжилтийн хувь

хэмжээ өсөж байгаа ч улсын дундаж 68.7 хувь байхад манай аймгийн 65.8 хувьтай байгаа нь сумдын Засаг дарга, ОНХС-ийн үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журмын хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулсан, ажилдаа хариуцлагагүй ханддаг байдал нөлөөлж байна.

1.1.4 Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлтөд малын тоо толгойн албан татварын орлогыг төсвийн тухай хуулийн дагуу төлөвлөж байгаа бол Алтай, Мянгад сум 2023 оны төсөвт дутуу төлөвлөсөн байна.

Малын тоо толгойн албан татварын орлогыг 1,223.8 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 772.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 451.4 сая төгрөгөөр тасарсан нь Булган сум 16.0, Дөргөн сум 26.8, Дуут сум 112.4, Зэрэг сум 62.2, Манхан сум 34.9, Мөст сум 5.2, Үенч сум 38.2, Ховд сум 55.9, Цэцэг сум 61.6, Чандмань сум 139.0 сая төгрөгөөр орлогоо бүрдүүлээгүйгээс сум, орон нутагт бэлчээрийн менежментийг сайжруулах төсөл, арга хэмжээнд хуульд заасны дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Иймд сум бүр малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг сумын ИТХ-аар батлуулж, бүрэн төвлөрүүлэх талаар төрийн захиргааны албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн харилцах дансанд 2022 оны эцэст 3,468.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй, үүнээс аймаг, сумын ИТХ-аар ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг 3,610.8 сая төгрөгөөр буюу 142.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн зарцуулахаар баталжээ.

¹ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

Өмнөх оны дансны үлдэгдлээс аймаг 400.0 сая, Буянт сум 19.5 сая, Мянгад сум 12.2 сая, Ховд сум 1.0 сая төгрөгөөр илүү, Дарви сум 21.3 сая, Дөргөн сум 38.9 сая, Зэрэг сум 40.7 сая, Цэцэг сум 174.6 сая, Манхан сум 8.3 сая, Чандмань сум 5.3 сая төгрөгөөр дутуу баталсан нь сангийн эх үүсвэрийг бодитой төлөвлөхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5-д заасны дагуу МоЭнКо ХХК-иас 8,143.0 сая төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 7.745.3 сая төгрөгийн орлого бүрүүлж 397.7 сая төгрөгийн орлогыг дутуу бүрдүүлсэн нь тайлант хугацаанд тээвэрлэсэн нүүрсний хэмжээтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- МоЭнКо ХХК-иас авах санхүүжилтийг 4.1 сая төгрөгөөр дутуу тооцоо нийлж баталгаажуулсан,
- МоЭнКо ХХК болон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг дүгнээгүй,
- Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээг аймгийн Засаг дарга болон Төфисмайнг ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дууссан одоог хүртэл шинэчлэн байгуулаагүй, гэрээг дүгнээгүй:

1.2 Зарим сумууд сангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого чиглэлтэй уялдуулан төлөвлөөгүй, хуулийн шаардлага хангаагүй, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг баталжээ.

1.2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 39,918.2 сая төгрөгийн 1,539 төсөл арга хэмжээнд санал авснаас цахимаар 5,022, цаасаар 25,479, бүлгийн ярилцлагаар 3,943 нийт 34,444 иргэнээс санал авсан байна. Энэ нь аймгийн хэмжээний 18-аас дээш насны 54,893 иргэнээс 34,444 иргэн буюу 62.7 хувь нь хамрагдсан байна.


Иргэдийн саналыг эрэмбэлэн 32,572.6 сая төгрөгийн 845 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж, 694 төсөл арга хэмжээний 7,345.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь нэн шаардлагатай бус, эдийн засгийн үр өгөөж бага, техник эдийн засгийн үзүүлэлт, зураг төсөвгүй зэрэг шалтгаанаар хасагдсан байна.

Аудитын явцад авсан санал асуулгад аймгийн хэмжээнд 365 иргэн хамрагдсан иргэдийн оролцоо хангалтгүй учраас санал асуулгын дүнгээр ОНХС-ийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна.

Дүрслэл 4: Санал өгсөн иргэдийн тоо



Дүрслэл 5: Иргэдийн мэдээллийн талаарх санал асуулгын дүн



1.2.2 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9², Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2³, 63.3⁴, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1⁵, 4.1.3⁶-т заасныг үндэслэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, сумд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж төлөвлөлтийг хийгээгүй байхад аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна. Сумын ОНХС-гийн хөрөнгөөр орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хамааралгүй ажлуудыг төлөвлөж баталдаг байдал тасрахгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Цэцэг сум сангийн хөрөнгөөр 19.9 сая төгрөгөөр сумын 100 жилийн ойг угтах хөтөлбөр,
- Чандмань сум сумын Хүндэт иргэн” тэмдэг, ном бэлтгэхэд 15.0,
- Алтай сум “Сумын 100 жилийн ойн бэлтгэл” хөтөлбөрөөр 19.9 сая,
- Мянгад сум кино, контент, Монгол адууны судалгааны ном хэвлүүлэх,
- Дарви сум “Хөшөөт 50 жил кино” хийх гэсэн утгаар хөтөлбөр арга хэмжээг батлуулсан

² Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.


³ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

⁴ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

⁵ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх

⁶ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх

1.2.3 Аймаг сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 2023 онд нийт 845 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 36.7 хувь буюу 11,949.8 сая төгрөгийг барилга байгуулж, 25.5 хувь буюу 8,309.9 сая төгрөгийг их засварт, 16.6 хувь буюу 5,147.9 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад, аймаг сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 18.3 хувь буюу 5,961.1 сая төгрөгийг ТАХ-нд 2.9 хувь буюу 1,203.9 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөжээ. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр



баталсан хөрөнгө оруулалт, төсөл, төсөл арга хэмжээ нь Сангийн сайдын 2023 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.6⁷ дахь заалтыг зөрчин иргэдийн санал аваагүй, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй ажлуудыг жагсаалтад оруулан аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Тухайлбал:

- Жаргалант суманд аймгийн Засаг даргын захирамжаар эрх шилжүүлсэн 1,265.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй, ажлын даалгавар, тоо хэмжээ байхгүй тул Жаргалант сумын захирагчийн ажлын алба нь ажлын даалгавар, тоо хэмжээг гаргаж шууд гэрээ байгуулсан;
- Мянгад сумын сургуулийн заалыг урлагийн заал болгох 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил мөн зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй байна.
- Иргэдээс ирсэн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулсан, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, материалыг аудитад ирүүлээгүй, иргэд, сум байгууллагаас ирүүлсэн саналуудыг хэрхэн тусгаж батлуулсан нь тодорхойгүй

Аудитын илрүүлэлт

- Үенч сум иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй сумын ЗДТГ-ын байрны урсгал засварын ажил,
- Цэцэг сум “Өргөө гэрийн тохижилт” иргэдийн санал аваагүй
- Мянгад сум Алтан хөхий уулсын тахилга ёслолын арга хэмжээ нь иргэдийн санал аваагүй
- Мянгад адууны судалгааны ном хэвлүүлэх, Тахилгын контент бичлэг хийлгэх ажил иргэдийн санал аваагүй
- Булган сум Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн ажил иргэдийн санал аваагүй,
- Жаргалант сумын “Наран багийн бичил үйлчилгээний төв” барилга барих ТАХ-ний төсвийг батлахдаа газрын зөвшөөрөл, дулааны техникийн нөхцөл зэргийг аваагүй, гадна дулааны шугамын ажлыг төсөвт тусгаагүй, төсөвт магадлал хийлгээгүй,
- Жаргалант сумын “ухаалаг худаг шинээр гаргах” ТАХ-г төлөвлөхдөө уст цэгийн судалгаа хийлгээгүй, хяналтын төсвийг хянаагүй гэрээ байгуулсан, ашиглалтын шаардлага хангахгүй ажлын даалгавар боловсруулсан,
- Жаргалант сумын “Буянт багийн өрхийн эрүүл мэндийн төв”-ийн барилгын дулааны техникийн нөхцөл аваагүй, төсөвт магадлал хийлгээгүй төлөвлөсөн,
- Цэцэг, Мөст, Үенч, Алтай сум сангийн хөрөнгийг “ИТХ хөтөлбөр арга хэмжээ” гэсэн утгаар төлөвлөн батлан ИТХ-ын төлөөлөгч, сумдын ЗДТГ-ын албан хаагчдийг чадавхжуулах болон урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан

1.2.4 Батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 4.2-т заасан чиг үүргийн дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталсан ч аймгийн Засаг даргын чиг үүрэгт хамааралгүй,

⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх

журмын 4.7.2⁸, 4.7.6⁹ дахь заалтуудаар хориглосон дараах арга хэмжээг аймгийн ОНХС-гийн хөрөнгөөс санхүүжүүлжээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт


- Зуны үдэш-2023 залуучуудын шоу тоглолтын зардалд 4.0 сая
- Казак түмний өв соёл, арга хэмжээний зардалд 5.0 сая
- Шигшмэл хурд-2023 уралдааны зардалд 15.1 сая төгрөгийг тус тус зарцуулжээ

Аймгийн ОНХС-аас хэрэгжүүлэхээр Засаг даргын үйл ажиллагааны 29 дэд хөтөлбөрт 105 зорилт, 529 арга хэмжээнд 1,590.3 сая төгрөгийг зарцуулахаар ИТХ-аас батлагдаж, гүйцэтгэлээр 1,585.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй дэд хөтөлбөрийн санхүүжилтийг хэрэгжүүлэх ажлын

Дүрслэл 7

ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР



төлөвлөгөөнд үндэслэлгүйгээр бөөн дүнгээр баталсан нь хөтөлбөрийн хэрэгжилт хангагдахгүй, зориулалт бусаар зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

БҮЛЭГ 2. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД НИЙТ 845 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТЛАГДСАНААС 81.3 ХУВЬ НЬ БҮРЭН, 10.7 ХУВЬ НЬ ДУТУУ ХЭРЭГЖИЖ, 8 ХУВЬ НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.


2.1 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж төсвийг хэт жижиглэн баталсан, батлагдсан ажлын даалгаврыг өөрчилдөг, хөрөнгө оруулалтын ажлыг эхлээгүй байхад гүйцэтгэгч нарт санхүүжилт олгосон, гэрээг удаа дараа сунгаснаар авлагыг нэмэгдүүлсэн.

2.1.1 Аймгийн хэмжээнд 32,572.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 845 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар батлуулагдаж үүнээс 10,883.5 сая төгрөгийн 45 төсөл арга хэмжээг нээлттэй тендерээр, 4,047.1 сая төгрөгийн 98 төсөл арга хэмжээг онцгой журмаар, 1,278.8 сая төгрөгийн 77 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авалтаар, 13,432.2 сая төгрөгийн 558 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийгдсэн байна.

⁸ Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал

⁹ Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал

Дүрслэл 8. Худалдан авах ажиллагааны хэлбэр



Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин ижил төстэй арга хэмжээг нээлттэй тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан, ажлын даалгавар болон ажлын тоо

хэмжээг өөрчилдөг дутагдал нийтлэг байна.

Зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга хэмжээг жагсаалтад оруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгч аж ахуйн нэгж шалгарсны дараа зураг төсвийг хийлгэж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

Аймаг, сумдаас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлахад оролцогч ирдэггүй, шалгарсан ААНБ нь ажлын дадлага туршлага муу, ажиллах хүчний нөөц хангалтгүй зэрэг асуудлууд нь худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад хүндрэл бий болгодог. Ажлын даалгаварт тусгасан ажлыг өөрчилдөг, захиалагч байгууллагаас даалгаварт тусгаагүй ажлыг гүйцэтгэх санал гаргадаг, гэрээнд заасан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээг сунгадаг зэрэг зөрчил нийтлэг байна.

Аудитын илрүүлэлт:

1. Булган сумын төсөвт байгууллагуудын хичээлийн байр, спорт заал, дотуур байрны цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээний холболт, цахилгааны үүсгүүр холбох ажлыг тус тусад нь шууд гэрээ байгуулж Булган Түшиг ХХК гүйцэтгэсэн,
2. Мөст сумын Хужирт багт гүүрэн гарам барих ажлыг 3 хуваан шууд гэрээ байгуулан Оргил жи трейд ХХК 57.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн,
3. Алтай, Буянт, Мянгад, Манхан, Мөст, Үенч, Ховд, Жаргалант зэрэг сумдууд худаг гаргах, гудамж тохижуулах, гэрэлтүүлэг, зам засах, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг ажлуудыг ХАА ажиллагаа зохион байгуулахгүйгээр ажлын даалгавар боловсруулан шууд гэрээ байгуулсан,
4. Шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамж, /Хатуу хөтөл чиглэл/ барих ажил 6кв болон 0.4кв шугам барих 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг ажлын тоо хэмжээгээр худалдан авах ажиллагааг зарлаж гүйцэтгэгч байгууллага шалгарсны дараа зураг төсвийг гаргасан байна. Гүйцэтгэгч байгууллага нь төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ажлын тоо хэмжээгээр гүйцэтгээгүй зургын дагуу гүйцэтгэсэн,
5. Аймгийн ОНХС-аас Жаргалант суманд эрх шилжүүлсэн хогны менежментийг хэрэгжүүлэх 1027.0 сая төгрөгийн ажлыг Жаргалант сум худалдан авах ажиллагаа зарлахгүйгээр Жаргалант сумын онцгой комиссын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн №03 тоот тогтоол гаргуулан шууд гэрээ байгуулсан,
6. Аймгийн ОНХС-аас Буянт суманд эрх шилжүүлсэн сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтын ажлыг батлагдсан тоо хэмжээний дагуу гүйцэтгээгүй захирал санал болгосон тоо хэмжээгээр гүйцэтгэсэн,
7. Жаргалант сумын Бичигт баг “Бичил бизнес үйлчилгээний байр” худалдан авах ажлын даалгаварт заасан шаардлагад нийцээгүй, зориулалтын дагуу шууд ашиглах боломжгүй барилга худалдан авсан,

¹⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ

8. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Мал эмнэлгийн хашаа барих ТАХ-ний ажлыг хэсэгчлэн 3 хуваан гэрээ байгуулсан, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, Мал эмнэлгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авахдаа ажлын тоо хэмжээ тусгаагүй,

2.1.2. Аймгийн хэмжээнд 845 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс тайлант онд 29,045.2 сая төгрөгийн 778 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ байгуулснаас 22,669.6 сая төгрөгийн 687 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 6,375.6 сая төгрөгийн 91 төсөл арга хэмжээ дутуу, 3,031.1 сая төгрөгийн 67 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Тайлант онд бүрэн хэрэгжсэн 687 төсөл арга хэмжээнээс 72 төсөл арга хэмжээний 1,392.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

Мөн дутуу хэрэгжсэн 91 төсөл арга хэмжээнд 4,751.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь сангийн хөрөнгийн үр дүнг бууруулсан байна.



Аудитын илрүүлэлт:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Бичигт багт "Бичил бизнес үйлдвэрлэлийн төвийн барилга"-ын засварын ажлын даалгаврыг өөрчилж шалыг паркетээр солих, таазыг будах ажлыг ламперээр сольсон, нэмэлтээр хаалга сольсон, цонх шиллэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн, Ганган нуур ХХК-ийн нийлүүлсэн Жаргалант сумын ЕБС-уудад ашиглагдаж байгаа ширээ сандлууд нь салж эвдэрсэн, зарим нь цаашид ашиглах боломжгүй болсон, ажлын дааврыг боловсруулахдаа насны ангилал, үнэ өртгийг бодитой судалгаан дээр үндэслээгүй,

2. Аймгийн ОНХС-ийн эцсийн гүйцэтгэлийг тооцож буй ХОХБТХ-ийн мэргэжилтэн, албан тушаалтнууд төсөвт тусгагдсан зохиогчийн хяналтын зардлыг тооцож аваагүй,

3 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг ААНБ-тай байгуулсан ажлын гэрээнд заасны дагуу гэрээний үүргээ биелүүлээгүй 2-оос дээш жил дамжин хэрэгжээгүй сангийн хөрөнгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй,

4.Аймгийн ОНХСийн авлага өмнө оноос 3,376.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, 2024 оны эхний хагас жилд ажлаа бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгөөгүй, 8 ажлыг дуусгах ажлыг зохион байгуулаагүй;

5. Алтай, Дөргөн, Ховд сумын Засаг даргын хөтөлбөрөөр ЗДТГ-ын автомашины засвар үйлчилгээний төлбөрийг төлсөн,

6. Цэцэг сумын Хөшөөт багийн худгийн барилга барих ажлын даалгаварт заасан мал услах онгоцны өртгийг тусгасан, гэрээнд өөрчлөлт оруулан уг ажлын үнийг суутган тооцоогүй, гэрээнд тусгасан хэмжээгээр гүйцэтгээгүй, гүйцэтгэх ажлын даалгавартай хүлээн авч данс бүртгэлд тусгасан, иргэдээс шүүмжлэл ихтэй,

7. Цэцэг сумын Улаан үзүүрийн худгийн барилга барих, худаг гаргах ТАХ-ний гэрээний хугацааг 2024 оны 04 сарын 24-нийг хүртэл сунгасан, мод усалгааны худгийн ТАХ-г хүлээлгэн өгөөгүй алданги тооцоогүй,

8. Чандмань, Мөнххайрхан сумдын ОНХС-ийн сангийн хөрөнгөөр "Бохирын машин", "хог тээвэрлэх машин", нийлүүлэхээр ХАА зарлагдсан ажлын даалгавар тухайн тээврийн хэрэгслийн гэрчилгээн дээр үйлдвэрлэсэн он, тээврийн хэрэгслийн суудлын бүс дээрх онууд хоорондоо зөрүүтэй байгаа нь ажлын даалгаврыг бодитой төлөвлөөгүй, үнэ ханшийн судалгааг нарийн тооцоогүй,

9. Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын тогтоолоор Хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ батлахдаа сумын "Тохижилт" гэсэн ТАХ-нд санхүүжилт олгосон ч тухайн ажил хийгдээгүй,

10. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрт хамааралгүй, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээнд 267.5 сая төгрөгөөр санхүүжүүлсэн,

11. Аймгийн ОНХС-аас Монгол хэл бичгийн дэд хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, сонгон шалгаруулалт зарлаагүй, үнэлгээ хийгдсэн эсэх нь тодорхой бус,



12. Малын эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрөөр 100 жилийн ойн гарын бэлэг, хөрөг нэвтрүүлэг, хэвлэлийн зардалд 23.4 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагаанд 8.0 сая төгрөгийг зарцуулсан,

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд үр өгөөжтэй, иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлсэн ч зарим төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй байна.

2.2.1 Аймгийн хэмжээнд 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн нийт 22,669.6 сая төгрөгийн 687 төсөл арга хэмжээг хөдөө аж ахуй, агааржуулалт, барилга, усан хангамж, боловсрол, эрүүл мэнд зэрэг иргэдийн болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Аудитын явцад бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 20,742.1 сая төгрөгийн 679 төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 1,937.5 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байгаа ч нийт төсөл арга хэмжээний хүрээнд авч үзэхэд дараах зөрчил дутагдал нийтлэг байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

1 Мөст сумын ЗДТГ-ын засврын ажил гүйцэтгэх гэрээг байгуулан санхүүжилт олгосон, хувь иргэнээр гүйцэтгүүлсэн, захиалагч байгууллагаас хүлээн авсан актгүй, төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааны зардал хэрэгжүүлэхээр баталсан үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй байх,

2.Дарви сум багийн дарга нарыг унаажуулах, ус цэвэршүүлэгч төхөөрөмж худалдан авах ТАХ-г тайлант оны төсөвт батлаагүй,

3. Манхан сумын ОНХС-ийн 2022 оны санхүүжилтээр Улаан хүрээ багт гүүрэн гарам барих ажлыг 10.0 сая төгрөгөөр батлагдаж 2023 онд ажлын даалгаварт заагдсан тоо хэмжээнээс нэмэгдүүлэн нэмэлт гэрээ байгуулаагүй аман хэлбэрээр хийгдэж уг ТАХ өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй, төсөвт өртгийг нэмэгдүүлэх шаардлага гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн,

4. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөтөлбөр төсөл арга хэмжээнд хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй, техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар, зураг төсөвгүй ажлын даалгавар тоо хэмжээ, төсөвт өртгийг тооцдоггүй;

5. Төрийн захиргааны албан хаагчдыг чадваржуулах, Ахмадаа ачлая хөтөлбөр, Залуучуудыг дэмжих, Алтан Хөхий уулын тахилга, ёслолын арга хэмжээ, Монгол бичиг үндэсний хөтөлбөр, Чадварлаг багш хөтөлбөр,

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр,Эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр батлаж байгаа хэдийч хөтөлбөрийн үр дүнг тооцдоггүй ;

6. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Жаргалант суманд "Нийтийн халуун ус сауны цогцолбор"-ын барилгыг улсын комисс хүлээн авсан, ажлын даалгавар, зураг төсөвт тусгасны дагуу халаалтын тогоог суурилуулсан ч уг тогоо нь халуун усаар хангаж чадахгүйгээс зориулалтын дагуу ашиглагдахгүй,

7. Зэрэг сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Гэр хорооллын хашааг шинэчлэх болон хаягжуулах" ажлын гүйцэтгэхээр Их морьт эрдэнэ ХХК-тай гэрээ байгуулсан гэрээнд заасан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, гэрээний 6.1-д заасан алданги тооцоогүй гэрээний үүргээ биелүүлээгүй;

8. Булган сум Онхотын булаг ХХК-тай Бүрэнхайрхан багт суваг шуудуу хийх ажлын гэрээг өөрчлөн Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг гүйцэтгэсэн, Мянгад сум багийн ИНХ-аар санал авч эрэмбэлэгдээгүй Алтан хөхий уулсын тахилга ёслолын арга хэмжээ, Мянгад адууны судалгааны ном хэвлүүлэх, Тахилгын контент бичлэг хийлгэх зардлыг сумын ИТХ-аар баталсан;

9. Мөнххайрхан сумын Цаг уурын 103.0 сая төгрөгийн өртөгтэй барилгын зурагт тусгасан өрөөний зохион байгуулалтыг өөрчилсөн,

10. Манхан сум 2023 оны төсвийн тодотголоор “нийтийн эзэмшлийн зам талбай засах” гэсэн ТАХ-ны нэршлийг өөрчлөн сумын “орох, гарах” хаалгыг 20.0 сая төгрөгөөр гүйцэтгэн захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн ч бусдын буруутай үйл ажиллагаанаас эвдэрсэн,

11. Жаргалант сумын Наран баг “Бичил үйлчилгээний төв”, Ухаалаг худаг шинээр гаргах, Баатархайрхан баг “7 дугаар сургуулийн доод уулзвараас шинэ түлшний зах хүртэлх сайжруулсан зам гүйцээж хийх, “Нийтийн тээврийн үйлчилгээнд автобус худалдан авах” ажлын гэрээний хугацааг удаа дараа сунгалт хийсэн, гэрээнд заасан хугацаандаа хүлээлгэн өгөөгүй нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй,

12. Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр Буянт багийн Өрхийн ЭМТөв-ийн барилга барих ажлын тоо хэмжээнээс дутуу, гэрээнд заасан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй,

13. Жаргалант сумын багуудад ухаалаг худаг шинээр гаргах ажлаас 2 худаг дутуу гүйцэтгэсэн,



14. Наран баг Бичил үйлчилгээний төвийн барилгын ажлыг гүйцэтгэж байгаа компани нь ажлаа гэрээний хугацаандаа хүлээлгэж өгөөгүй,
15. Нийтийн тээврийн үйлчилгээнд автобус худалдан авах ажлыг "Мөнх цаст хаан" ХХК гэрээний хугацаанд гүйцэтгэж, хүлээлгэн өгөөгүй,
16. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр аймгийн ЗДТГ-аар дамжуулан Өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний зардлаас эрдэнэ шишийн даршийг 625 уутыг бэлтгэсэн ч 600 уутыг Онцгой комиссын шийдвэр гаргуулан акталсан нь сангийн хөрөнгийн өгөөжийг бууруулсан,

2.2.2 Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гудамж талбайд гэрэлтүүлэг тавих, зам засвар, худаг ус, малжуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, нийтийн эзэмшлийн засвар хийгдсэнээр иргэд, ард түмний ая тухтай, аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдүүлэн үр өгөөжөө өгч байна.

САЙН ЖИШЭЭ:

- ✓ Чандмань сумын ОНХС-ийн хөрөнгөөр Соёлын төвийн номын сангийн уншлагын танхим тохижуулах тавилга, эд хогшил нийлүүлснээр номыг стандартын дагуу хадгалах, үйлчлэгчийн ном унших таатай орчин бүрдсэн,
- ✓ Мөст суманд нийлүүлсэн ковш-50 маркийн трактор, сумын төвийн айл өрхүүдийг үер усны аюулаас хамгаалах боломж бүрдсэн,
- ✓ Алтай сумын ЭМТ-д ЭХО аппарат, Эрдэнэбүрэн сум Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппаратыг авснаар сумын иргэд үзлэг оношилгоо, шинжилгээг сум орон нутагтаа хийх боломж бүрдсэн,
- ✓ Үенч сум айл өрхүүдийн цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор трансформатор нэмж суурилуулснаар иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлсэн,
- ✓ Булган сумын 14 төсөвт байгууллагуудыг 20 гаруй барилга байгууламжийг цэвэр, бохир усны инженерийн шугамын холболтыг 621.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь албан хаагчдын ажиллах ард иргэдийн үйлчлэх таатай орчин, хүүхдийн сурч боловсрох таатай орчин сайжирсан,
- ✓ Булган суманд хөдөө нутагт нарийн мэргэжлийн эмчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор “Орон сууц”-аар хангах зорилгоор 2 өрөө байр худалдан авсан,
- ✓ Дарви сумын ЭМТ-д авто машин нийлүүлснээр ойрын дуудлага, аймагт өвчтөн хүргэхэд цаг хугацаа, шатахуун хэмнэсэн нь үр өгөөж бий болсон.
- ✓ Мөнххайрхан сумын төвийн айл өрх, албан газруудыг хог хаягдлыг зайлуулахад “Хогны машин” авснаар сумын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил болсон байна.
- ✓ Манхан сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг, сумын түүхт 100 жилийг угтан Соёлын төвийн урлагийн хувцас шинэчлэх зэрэг ажлууд үр дүнтэй хийгдэж сум болон байгууллагын өнгө үзэмжийг нэмсэн,
- ✓ Жаргалант сумын ОНХС-аар хийгдсэн Их монгол хорооллын гадна болон дотор тохижилт, авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбай,
- ✓ Шинэ суурьшлын бүсийн айл өрхүүдийг цахилгаан эрчих хүчээр хангасан ажил үр дүнтэй багийн иргэдийн ая тухтай орчинг бүрдүүлсэн,
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Жаргалант сумын Цамбагараг, Магсаржав багийн иргэд, хөдөлмөрчдийг зуны улиралд хэрэглээний халуун усаар хангасан нь иргэдийн сэтгэлд нийцсэн арга хэмжээ болсон,
- ✓ Шинэ суурьшлын бүсэд баригдаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн нь иргэдийн ая тухтай орчныг хангасан,
- ✓ Тулгын 30 айлын гаднах тоглоомын талбайн ажил нь хүүхдүүд тоглож наадах таатай орчныг бүрдүүлсэн,



2.3 Сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулан хариуцах эзнийг тодорхой болгох, ашиглалтын зардлыг төлөвлөх шаардлагатай байна.

2.3.1. Тайлант онд хэрэгжүүлсэн 687 төсөл арга хэмжээнээс зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа 21,172.1 сая төгрөгийн 679 төсөл арга хэмжээ, зориулалтын дагуу ашиглахгүй байгаа 46.2 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, огт ашиглахгүй байгаа 1,451.3 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг бодитой хийгээгүйгээс, орон нутгийн хэрэгцээ

шаардлагад үндэслэн төлөвлөөгүйгээс, ашиглалтыг зөв зохион байгуулаагүй зэргээс шалтгаалан зарим хөрөнгө оруулалтын ажлууд нь зориулалтын дагуу ашиглагдахгүй байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Нийтийн халуун ус, сауны цогцолборын 2,650.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй ажлыг улсын комисст хүлээлгэн өгсөн ч одоог хүртэл иргэдэд үйлчилгээ үзүүлээгүй;
- Бичигт багт аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Бичил бизнес үйлдвэрлэлийн төвийн барилга нь бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй, зарим өрөөнүүд нь одоог хүртэл сул;
- Шинэ ховд Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-ын ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 165.0 сая төгрөгөөр худалдан авч өгсөн 50 ковш тракторыг хүлээн авсан боловч ашиглалтын явцад эвдэрсэн,
- Жаргалант сумын Их гүүрний нийтийн эзэмшлийн газрын тохижилтын ажлын ашиглалт хамгаалалт муу, өмнөх онд хэрэгжүүлсэн 84.0 сая төгрөгийн өртөгтэй хашаа чанаргүй,
- Жаргалант суманд өмнөх онд хэрэгжүүлсэн мах, сүү, ногоо, жимс борлуулах цэгүүдийг бүрэн ашиглахгүй байгаа,
- Мөн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай, усан оргилуур бүхий цэцэрлэгт хүрээлэн, шуудан холбооны салбар барилга зэрэг орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт муу,
- Баатархайрхан багийн Зах орчмын нийтийн эзэмшлийн тохижилтоор хийгдсэн ажлын 2ш сандал, 4ш хогийн сав алга болсон,

2.3.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зарим ажлууд нь чанаргүй хийгдсэн, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан ч өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, зарим хөрөнгө оруулалтын ажлууд нь баталгаат хугацаандаа эвдэрсэн, цаашид ашиглах байгууллагыг ИТХ-аар хэлэлцүүлэн тодорхой болгоогүйгээс хөрөнгийн үр өгөөжийг бууруулжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийн харуул хамгаалалт, ашиглалт, урсгал зардлыг дутуу төлөвлөснөөс хөрөнгө эзэнгүйдэх, эвдэрч гэмтэх эрсдэлтэй байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Буянт сумын ЕБС-д тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ-ээр ашиглах боломжгүй принтер хүлээлгэн өгсөн;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Нийтийн номын сангийн дэргэдэх тохижилтын ажлын даалгаврын дагуу хийгдсэн савлууран тоглоомын тулгуур төмөр хугарч эвдэрсэн;
- Булган, Цэцэг, Буянт, Дарви, Мянгад, Үенч, Мөст, Дөргөн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2022-2023 онуудад Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэн”-д сумдын онцлогийг хамруулах зорилготой төсөл арга хэмжээгээр нийт 110.1 сая төгрөгөөр “хөшөө” хийгдэж уг хөрөнгийг данс бүртгэлд тусгах, хадгалалт хамгаалалтыг хариуцах эзэн тодорхойгүй, холбогдох байгууллагын шийдвэргүй,
- Сумдын ОНХС-аас гэрэлтүүлэг, хашаажуулах, хаягжуулах, худаг гаргах, дулааны шугам татах зэрэг ажилд иргэдийн оролцоотойгоор хөтөлбөр нэрээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах эсэх нь тодорхой бус,

БҮЛЭГ 3: ОНХС-ИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭЖ ГАРГААГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БЭЛТГЭСЭН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ, УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН ОРУУЛААГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас хяналтыг хэрэгжүүлсэн ч илэрсэн алдаа зөрчил бүрэн арилаагүй байна.

3.1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4¹¹-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн ИТХ-ын даргын 2023 оны А/33 дугаартай захирамжаар аймагт 2022-2023 оны улсын

¹¹ “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина”

болон орон нутгийн хөрөнгө оруулалтын чанар үр дүнд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилон 13 сумдад ажиллаж хэрэгжүүлсэн ажлын тайлан, хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг сум, төсөл арга хэмжээ бүрээр гарган аймгийн ИТХ-д 8 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын албанаас Булган, Мөнххайрхан, Дуут, Үенч, сумдын ОНХС-ийн 2022-2023 оны зарцуулалтад хийгдсэн хяналтаар 391.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 224.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 75.7 сая төгрөгийн албан шаардлага 91.4 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд Жаргалант, Алтай, Дарви, Дөргөн, Мянгад, Манхан, Ховд сумдын ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 5.3.1¹²-дэх хэсэгт захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг заасны дагуу Жаргалант, Булган, Буянт, Дуут, Зэрэг, Манхан, Мөнххайрхан сумууд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Захиалагчаас хэрэгжүүлэх хяналт шалгалтад төсөл, арга хэмжээг бүрэн хамруулаагүй, хяналтыг үр дүнтэй хийгээгүйгээс ажлын тоо хэмжээнээс дутуу, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан, гэрээнд заасан хугацаанд гүйцэтгүүлэхгүй байгаа нь төсөл арга хэмжээ нь чанаргүй гүйцэтгэх, хөрөнгийн үр ашиг буурах, хөрөнгө оруулалт үр дүнгүй хэрэгжих эрсдэл байна.

3.1.3. ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2022 онд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитаар нийт 811.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 21.3 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд төлбөрийн акт, 687,2 сая төгрөгийн 18 алдаа зөрчилд албан шаардлага, 103.3 сая төгрөгийн 18 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

д/д	сумын нэр	Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж			
		Тоо	Мөнгөн дүн	Биелэлт	Хэрэгжилтийн хувь	Тоо	Мөнгөн дүн	Биелэлт	Хэрэгжилтийн хувь	Тоо	Мөнгөн дүн	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Жаргалант сум									1	57.0	57.0	100
2	Мөст сум					1	11.0	11.0	100				
3	Чандмань сум					1	75.0	75.0	100				
4	Аймгийн ОНХС	3	21.3	21.3	100	16	601.2	601.2	100	10	46.3	46.3	100
	дүн	3	21.3	21.3	100	18	687.2	687.2	300	11	103.3	103.3	100

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлсэн боловч 2023 оны ОНХС-ийн хөрөнгөд хийгдэж буй гүйцэтгэлийн аудитаар дээрх илэрсэн алдаа зөрчил дахин давтан гарсаар байгаа нь хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын илрүүлэлт:
1. Сангийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй,

¹² Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ;

2. Амарсанаагийн цэнгэлдэх хүрээлэнд хийгдсэн 47.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийтийн бие засах газрыг одоог хүртэл эзэмшлийн асуудлыг шийдээгүйгээс, нийтэд үйлчилгээ үзүүлээгүй;
3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Манхан сумын “Ахуй үйлчилгээний барилгын засвар хийх 100.0 сая төгрөгийн өртөг төсөл, арга хэмжээ одоог хүртэл хэрэгжүүлээгүй, хүлээлгэн өгөөгүй,
4. Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн журамд заасны дагуу сангийн жилийн эцсийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн талаарх баримт материалгүй,

Аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,117.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 177.2 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 762.6 сая төгрөгийн 8 албан шаардлага, 2,218.9 сая төгрөгийн 34 заалт бүхий зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж, 959.1 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Хүснэгт 3 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл (сая.төг)

д/д	сумын нэр	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Алтай			1	10.0	3	662.2		
2	Булган					1		3	186.3
3	Буянт					4	70.3	2	49.0
4	Дарви	1	31.8	1	469.3	3	968.2	3	389.9
5	Дөргөн	1	64.6	1	148.5	4	36.2	1	13.6
6	Дуут					1	6.4		
7	Зэрэг			1	16.0	2	7.3		
8	Жаргалант	2	7.9			3	120.3		
9	Манхан					2	9.1	1	34.0
10	Мөнххайрхан					1			
11	Мянгад			1	20.0	1			
12	Мөст			1	9.8	3	51.6	1	1.0
13	Цэцэг					1	107.1	3	107.8
14	Ховд					2	10.5		
15	Үенч	2	27.5			1	29.9	2	177.5
16	Чандмань					1	21.6		
17	Эрдэнэбүрэн	1	4.0	2	89.0	1	118.2		
18	Аймгийн ОНХС	1	41.4						
ДҮН		8	177.2	8	762.6	34	2,218.9	16	959.1

Эх сурвалж нь Ховд аймаг дахь Төрийн аудитын мэдээ

3.2 Сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг журамд заасны дагуу тайлагнаж хүргүүлээгүй байна.

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2, 9.3, 9.9, 9.10, 9.11 дүгээр бүлэгт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хүргэх, тайланд тусгах мэдээллийг дараах байдлаар зохицуулсан байна.

Хүснэгт 4: Тайлан хүргүүлэх хугацаа, мэдээлэл

Хариуцах нэгж, албан тушаалтан	Тайлагнах хугацаа	Хүргүүлэх албан тушаалтан	Тайланд тусгах мэдээлэл	Тайланд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх арга хэмжээ
9.2/9.3 заалт Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	Дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хүргүүлнэ.	9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр; 9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр; 9.9.3.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа; 9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;	1. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна. 2. Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын

			9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт; 9.9.6.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал; 9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга.	мэдээллийн хамт хэлэлцүүлнэ.
9.9/ 9.10 заалт Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг хүргүүлнэ.		Тайланд дүн шинжилгээ хийж, ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулна.

Эх сурвалж: 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам

Аймгийн ХБТХОХ нь журмын холбогдох заалтын дагуу аймгийн 17 сумдын ОНХС-ийн тайланг хүлээн авсан болон хяналт хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл, Сангийн яаманд холбогдох тайлан мэдээг хүргүүлсэн талаарх баримт материал, захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга, байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулсан, арга хэмжээ авсан тайланг аудитын явцад ирүүлээгүй.

Мөн хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн явцын тайланг дээд шатны байгууллагад хүргүүлж үр дүнг хэлэлцүүлээгүй, хяналт шалгалтын талаарх мэдээллийг олон нийтэд түгээгүй байна.

3.2.2 Холбогдох мэргэжлийн байгууллагуудаас томилогдсон ажлын хэсгийн комиссын актаар хүлээн авсан 34 төрлийн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2,678.2 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹³, 14.4.2¹⁴, 5 дугаар зүйлийн 5.1.4¹⁵ 18 дугаар зүйлийн 18.1¹⁶ дахь заалтуудтай нийцээгүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2,435.9 сая төгрөгийн 20 хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт:	
1.	Дарви, Цэцэг, Мөнххайрхан сумын ОНХС хөрөнгөөр хийгдсэн 3 нэр төрлийн 63.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгаагүй
2.	Буянт, Дарви, Дөргөн, Мянгад, Мөст, Үенч, Цэцэг сумын "Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт" ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан 7 нэр төрлийн 100.1 сая хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах байгууллага тодорхойгүй,
3.	Мянгад сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн мал угаалгын ванн барих 13.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
4.	Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Бичигт багт бичил бизнес үйлдвэрлэлийн төвийн барилгын их засварыг 63.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
5.	Мөст сумын сургуульд бөхийн дэвжээг нийлүүлсэн байгууллага ажлын даалгаварт тусгаснаас өөрөөр нийлүүлсэн тул комисс хүлээн аваагүй буцаасан, 18.2 сая төгрөгийн хөрөнгийг 2023 оны санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй,
6.	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Цахим үйлчилгээний хэлтэст 106.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсныг бүртгэлд тусгаагүй,


¹³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ
¹⁴ Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага
¹⁵ Нягтлан бодох бүртгэлд үнэн зөв байх зарчим баримтална
¹⁶ Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ

3.2.3 Сангийн сайдын 2021 оны 86 тоот тушаалын 10.2¹⁷-д ОНХС-гийн удирдлагын мэдээллийн системийг хэрэгжүүлэхээр, 10.2.1¹⁸-д сумын ЗДТГ нь холбогдох мэдээллийг 12 дугаар 25-ны дотор оруулахаар журамласан байна.


Удирдлагын мэдээллийн системд аймаг сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжиж буй төсөл арга хэмжээний тоо 643, ашиглалтад орох ажлын тоо 669-ийг бүртгэж 66 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын явцад нэгтгэсэн судалгаагаар УМС-д 2023 оны төсөл арга хэмжээний мэдээллийг нийт 845 төсөл арга хэмжээг мэдээлэхээс бүрэн оруулсан 453 мэдээлэл буюу 53.6 хувь, дутуу 224 оруулсан буюу 26.5 хувь, мэдээллийг огт оруулаагүй 168 төсөл арга хэмжээ буюу 19.9 хувьтай байна.

Дүрслэл 10. УМС-д оруулсан мэдээлэл (хувь)



Дүрслэл 11. УМС-д оруулсан мэдээлэл



Аймаг сумдын 2023 оны ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон нь сангийн үйл ажиллагааны журмын 10.3.2¹⁹, 10.3.3²⁰ дах заалтуудыг мөрдөөгүй байна.

3.2.4. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хянахад аймгийн ОНХС-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ОНХС, сумдын ОНХС-ийн хувьд 2023 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ОНХС-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээлбэл зохих мэдээллээ мэдээлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд нь мэдээлж ажилласан байна.

Аудитаар нийт 3,777.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 30.1 сая төгрөгийн 6 алдаа зөрчилд төлбөрийн акт, 949.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 69.9 сая төгрөгийн хариуцлага тооцох 1 албан

¹⁷ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ

¹⁸ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна

¹⁹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ;

²⁰ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй;

шаардлага, 19.9 сая төгрөгийн 2 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэх, 2,708.0 сая төгрөгийн 13 зөвлөмж өгөгдлөө.

ДҮГНЭЛТ

- ОНХС-д уул уурхайн компаниас гэрээний үүргийн орлогыг 8,143.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн сангийн эх үүсвэрийг төлөвлөсөн ч Төфисмайнг ХХК-аас орлого орох боломжийг алдсан байна.
- Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг төлөвлөснөөр төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.
- Засгийн газрын тогтоосон босго үнээс бага дүнгээр төсөл арга хэмжээг баталснаар орон нутгийн иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх төсөл арга хэмжээг санхүүжүүлэхгүй байна.
- Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, урсгал зардлын шинж чанартай зардалд зарцуулсан нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулжээ.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зарим төсөл арга хэмжээ үр дүнтэй хийгдсэнээр иргэдийн ая тухтай, аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн байна.
- Гэрээний хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сунгаснаар хөрөнгө оруулалтын ажил он дамжин хэрэгжиж байна.
- Нийтийн эзэмшлийн талбайд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлын цаашид гарах урсгал зардлыг төсөвт төлөвлөөгүйгээс хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.
- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд холбогдох байгууллагуудаас хэрэгжүүлсэн хяналтаар илэрсэн зөрчил арилахгүй байгаа нь ажлын чанар, үр дүнд нөлөөлж байна.
- Удирдлага мэдээллийн системд төсөл арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулахгүй байгаа нь иргэд ОНХС-аар хэрэгжих ажлын мэдээлэл авах эрх хангагдахгүй, хяналт тавих боломж бүрдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди-д зөвлөх нь:

- Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрийн санхүүжилтийг батлахдаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд үндэслэн бодитой төлөвлөх, хөтөлбөрийн үр дүнг ИТХ-аар хэлэлцүүлж тайланг олон нийтэд мэдээлэх

Аймгийн Засаг даргын үүргийг гүйцэтгэгч Х.Батболд-д зөвлөх нь:

- Хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгож, гэрээнд заасан хугацаанд ажлаа дуусгаагүй аж ахуйн нэгжүүдийн гэрээний хугацаа сунгадаг байдлыг таслан зогсоож, гэрээний алданги тооцон ажиллах.
- Иргэдээс ирсэн саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт гаргах ажлын хэсгийг томилон ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг гарган аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ИТХ-аар батлуулах
- ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг үр нөлөөтэй хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан ажиллах.

- *Тефисмайнг ХХК-тай гэрээ байгуулж, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж ажиллах.*
- *Зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, магадлалаар баталгаажаагүй хөрөнгө оруулалтын ажлыг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулахгүй байх, төсөл арга хэмжээний ажлын даалгавар, тоо хэмжээг гүйцэтгэх явцад өөрчилдөг байдлыг таслан зогсоох.*

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал-д

- *ОНХС-гийн төлөвлөлт, гүйцэтгэл тайлагналын мэдээллийг УМС-д бүрэн оруулж, хэрэгжилтэд хяналт тавих.*

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэбат-д

- *ОНХС-гийн заавар журмын 9 дүгээр 9.9-д заасан 12 мэдээлэл бүхий цогц тайланг гаргаж журамд заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллах*
- *Худалдан авах ажиллагаа зарласны дараа зураг төсөв гаргадаг байдлыг таслан зогсоож зураг төсөвгүй төсөл арга хэмжээг ажлын даалгавар, тоо хэмжээгээр сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөхгүй байх*

Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Энхбаяр-т

- *Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч данс бүртгэлд бүрэн тусгах ажлыг зохион байгуулах*

Сумдын Засаг дарга нарт

- *Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэхдээ хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох*
- *Сангийн хөрөнгөөр ИТХ-ийн төлөөлөгч нарыг чадавхжуулах болон үйл ажиллагааны зардал олгодог байдлыг таслан зогсоох*
- *Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, төсвийг батлуулахдаа төсөл арга хэмжээг хэт жижиглэн баталж байгааг зогсоох*

БАЙГУУЛЛАГУУДААС ИРСЭН САНАЛ:

Холбогдох байгууллагаас санал ирээгүй болно.